

Хөрвүүлэх програмд зөв бичих зүйн дүрмийг таниулсан нь

Э. Мөнх-Учрал (МУИС)

- I. Үгийг зөв бичих зүйн дүрмийн дагуу бүлэглэхэд ашигласан ойлголтууд
- II. Кирилл үсгийн дүрмийн онцлог, түүнийг програмд таниулсан нь, хэтийн зөгнөл
- III. Монгол бичгийн зөв бичих дүрмийн онцлог, түүнийг програмд таниулсан нь

I. Цахим үгийн санд монгол болон кирилл бичгийн зөв бичих дүрмийн дагуу оруулж хадгалсан бүх үгийн үндсэнд хэлзүйн судалгаа хийж, үг хувилгах алгоритмыг боловсруулснаар үгийн хэлзүйжсэн хэлбэрийг үүсгэж, задлах үйлдлийг уг хоёр бичгээр буй эхийг харилцан хөрвүүлэх програмын үндсэн зарчим болгон тодорхойлсон юм.

Үг хувилгах алгоритм нь кирилл үсгийн дүрэм, монгол бичгийн зөв бичих зүйн дүрэмд үндэслэнэ. Алгоритмын тусламжтайгаар тухайн үгийн хэлзүйн хувиллаар хувилах бүх боломжийг үүсгэхийн сацуу бүтцээр нь задалж чадна.

Бид уг алгоритмыг зохиох болон тус хоёр бичгийн зөв бичих дүрмийг програмд таниулахын тулд

1. үгийн аймаг
2. үгийн зөв бичих дүрмийн бүлэг
3. үгийн эгшиг гэсэн ойлголтуудыг гарган ашиглалаа.

Энэ гурван ойлголтын нэгдлийг үгийн санд буй үг бүрт тоон утгаар (бүлгийн дугаар) оноож өгөх бол монгол хэлний үгийг зөв бичих зүйн дүрмийн дагуу бүлэглэх нь бөгөөд үг, нөхцөл хоёрыг холбон бичих дүрмийн цогц мэдээлэл юм. Иймээс энэ бүх ойлголтууд үгийн үндэс, түүний хэлзүйн хэлбэр хоёрыг “зуучлагч”-ийн үүрэгтэй гэж болно.

Нэгд, Монгол хэлний үгсийг харилцан адилгүй аймаглаж ирсэн билээ.¹ Бид үгийн санд хадгалсан үгсийг хувилах, үл хувилах хэмээсэн ангиллыг барьж, хувилах

¹ 1966 онд ШУА-аас хэвлүүлсэн "Орчин цагийн монгол хэлзүй" номд: жинхэнэ нэр, тэмдгийн нэр, тооны нэр, үйл үг, дайвар үг, төлөөний үг, дагавар үг, сул үг, холбоос, аялга үг гэж 10 ангилсан байна. Ц. Жанчивдорж, Б. Рагчаа, Монгол хэлний үг зүй, (Улаанбаатар, 1967)-д бодит нэр, тэмдэг нэр, тооны нэр, төлөөний үг, үйл үг, дайвар үг, дагавар үг, сул үг, холбоос үг, аялга үг хэмээн ангилсан буй. 1987 онд ШУА, УБДС-аас хэвлүүлсэн "Орчин цагийн монгол хэлний үгзүйн байгуулал" бүтээлд монгол хэлний үгсийг үндсэн үг, туслах үг гэж ерөнхийд нь хоёр анги болгон хуваагаад, үндсэн үгээ нэр үг, үйл үг, тэмдэг нэр, дайвар үг, тооны нэр, төлөөний үг хэмээн 6, туслах үгээ дотор нь дагавар үг, сул үг,

үгсийг *нэр, үйл* хэмээж, үгийн аймгаа *нэр, үйл, үл хувилах* гэсэн 3 зүйлээр тодорхойлов. Эхийн доторх бусад үгсийн аймгийн, жишээлбэл тэмдэг нэр жинхэнэ нэрийн үүргээр орсон гэх мэт хувилсан тохиолдлууд нь үүнд бүрэн шингэж чадах учраас энэ ангилал бидний зорилгод нийцэж буй.

Хоёрт, нэр болон үйл үгийн үндсийг кирилл, монгол бичгийн зөв бичих дүрмийн дагуу бичигдэх хэлзүйн хувиллын ижил бичлэгээр ангилав. Үүнийг “*үгийн зөв бичих дүрмийн бүлэг*” гэсэн томъёоллоор илэрхийллээ.

Энэхүү бүлэг нь нэг талаас үгийн *үндсийн хэлбэр*, нөгөө талаас *эхний нөхцөл*-ийг багтаасан ойлголт юм.

Зөв бичих дүрмээс шалтгаалан тодруулбал, тодорхой залгавар бүтээврүүдийг залгахад кирилл үсгийн тухайд зарим үгийн үндсийн балархай эгшиг гээгдэх (*арал, арлын, арал-д, арлаас* г.м.), зөөлний тэмдэг “и” болж хувирах (*говь, гови-йн, говь-д, говиос* г.м.) зэргээр, монгол бичгийн тухайд бол “н”-ээр төгссөн үгийн үндэс их энхлэг болж хувирах (*qan-, qang-qu, qan-ju /хана-, ханах, ханаж/, ċin- ċing, ċing-kü, ċinü /чинэ-, чинэх, чинэж/* г.м.) гэхчилэнгээр үгийн үндэс өөрчлөгддөг. Үүнийг програмд таниулахын тулд “*үгийн үндсийн хэлбэр*” гэсэн ойлголтыг гаргасан болно. Үгийн хэлзүйжсэн хэлбэрийг үүсгэх, задлах үйлдлийг гүйцэтгэхдээ тухайн залгавар бүтээвэр үндсийн аль хэлбэрт залгагдахыг дүрмийн дагуу зааж өгсөн. Үндсийн хэлбэрийг цахим үгийн санд хадгалагдаж буй бүх үгсийн хувьд тооцож үзвэл, 0-3 хүртэл утгатай байна. 0, 1 гэсэн утга хамгийн түгээмэл.

0 хэлбэр бол тухайн үг ямар нэгэн хэлзүйн харьцаанд ороогүй, үндсээрээ байх үеийн хэлбэр юм.

1 утга нь балархай эгшигтэй үгс, зөөлний тэмдгээр төгссөн үгэнд хамаарч, өөрөөр хэлбэл, үгийн үндсийн балархай эгшигийг гэсэн хэлбэр, зөөлний тэмдэг “и” болсон хэлбэрийг илэрхийлнэ. Жишээлбэл, “бодол” – 0 хэлбэр бөгөөд тийн ялгалаас өгөх орших, хамтрах, чиглэхийн нөхцөл, биед хамаатуулах нөхцөлд (*бодол-д, бодолтой, бодол-руу, бодол минь, бодол чинь, бодол нь*); “бодл-“ 1 хэлбэр ба харьяалах, заах, гарах, үйлдэхийн тийн ялгал, эзэнд хамаатуулах нөхцөл 1 хэлбэрт (*бодл-ууд, бодл-ын, бодл-ыг, бодл-оос, бодл-оор, бодл-оо*) тус тус хамаарна.

2, 3-р хэлбэр нь олон тооны нөхцөл авах байдлаас, мөн төлөөний үгэнд хамаатайгаар гарч байна. Жишээлбэл, дархан гэдэг үгийн үндсийн 0 хэлбэр нь “дархан” бөгөөд өгөх орших, хамтрах, чиглэхийн тийн ялгалаа хувилах үед; 1 хэлбэр “дархн-“ харьяалах, заах, гарах, үйлдэхийн тийн ялгал, эзэнд хамаатуулах нөхцөлөөр хувилах үед; 2 хэлбэр “дарха-“ олон тооны “д” нөхцөлөөс хувилах үед; 3 хэлбэр “дарх-“ олон тооны “чууд, чуул” нөхцөлөөр хувилах үед тус тус шаардлагатай болох юм. Төлөөний үгст дээд утгадаа үндсийн 4 хэлбэр гарна. Жишээ нь, “би” гэдэг үгийн тухайд “би”-0, “мин”-1, “нам”-2, “над”-3 гэх мэт.

холбоос үг гэж 3 ангилжээ. Чойжинжав, *Монгол хэлний зүйн судлал*, (Хөххот, 1989)-д *биет үг, хийсвэр үг, аялга үг* хэмээн ерөнхийлөн ангилаад биет үгээ *нэр, үйл* гэж, нэр үгэнд *жинхэнэ нэр, тэмдэг нэр, тооны нэр, цаг орны нэр, төлөөний нэр* багтана, үйл үгэнд *энгийн үйл үг, холбох үйл үг, төлөөний үйл үг, туслах үйл үг* багтана гэжээ. 1997 онд ШУА, ХЗХ-ээс хэвлүүлсэн “*Орчин цагийн монгол хэл*”-д *гол ба туслах* хэмээн ангилж, цааш нь гол үгээ *нэр, үйл* гээд, нэр үгээ *хувилах, үл хувилах, хувилахыг нь бүрэн хувилах жинхэнэ нэр, заримдаг хувилах орон цагийн нэр, үл хувилахыг нь тэмдэг нэр, тооны нэр* гэж, үйл үгийг *бүрэн хувилах, заримдаг хувилах* гээд туслах үгсээ *чимэх үг, холбох үг* хэмээн ангилсан гэх мэт.

“Эхний нөхцөл” бол тухайн үгийн үндсэнд шууд, эхлэн залгагдах чадамжтай нөхцөл, бүтээврийн зохистой хэлбэрийн олонлог юм. Нэг зүйлийг тодруулахад, монгол толь бичгийн уламжлалаар толгой үгэнд орсоор ирсэн “-гүй”, “-чил”, “-хан”, үйл үгийн хэв гэх мэт зарим дагаврын зүйлийн хэрэглээг харгалзан эхний нөхцөлд багтаасан болно. Учир нь бүх үйл үг хамгийн багадаа нэг, мөн түүнээс олон хэвийн нөхцөлөөр хувилах боломжтой, бүх нэр үгс үгүйсгэх дагавар авах чадамжтай гэхчилэн тэр бүгдийг толгой үгэнд тооцож үгийн санд хадгалах нь програмын хурдад нөлөөлж, мөн үгийг задлах явцад бүрэн үр дүн харуулахгүй дутагдалтай. Тиймээс эхний нөхцөлд багтаан үг хувилгах алгоритмаар шийдвэрлэв.

Монгол хэлний үг хувилгах үүрэгтэй бүхий л залгавар бүтээврүүд нь нэрийн нөхцөлд, олон тоо, тийн ялгал, хамаатуулахын нийт 17 зүйл нөхцөл, үйлийн хэв, байдал, нөхцөлдүүлэн холбох, тодотгон холбох, биеэр төгсгөх, цагаар төгсгөхийн 68 зүйл, мөн үүний дээр үгүйсгэх “-гүй”, сэтгэлийн өнгө аяс илтгэх “-хан⁴”, “-чил”, хамаатуулах утгатай “-х, -хан⁴” гэсэн 4 бүтээвэр нийт 88 зүйл байна. Ингэхдээ бид хэрэглээний байдлыг харгалзан үзэж аливаа нөхцөлийн эрт эдүгээ цагийн бүхий л хэлбэрийг бүрэн бүртгэж орууллаа.

Гуравт, *үгийн эгшиг* нь монгол, кирилл бичгийн эгшиг зохицохуйг илэрхийлсэн ойлголт юм. Монгол бичгийн тухайд, эгшиг нь “чанга, хөндий”-өөр буюу эр, эмээр зохицно. Кирилл бичгээр эгшиг зохицох нь үгийн үндсэнд а, у тохиолдвол хойшид тохиолдох нь эгшиг нь а; э, ү, и бол э; о бол о; ө бол ө гэсэн дүрэмтэй.² Үгийн эгшиг нь нэг талаас тухайн үгийн үндсийн эгшийг, нөгөө талаас нөхцөлийн олонлогийн эгшгээр зохицох хэлбэрийг тодорхойлно.

II. Кирилл бичгийн зөв бичих дүрмийг хөрвүүлэх програмын алгоритмд хэрхэн тусгасан тухай өгүүлэхийн өмнө кирилл үсгийн дүрмийн талаар товчхон дурдъя.

Бидний хэрэглэж буй “кирилл үсгийн дүрэм”³ анх 1942 онд хэвлэгдэж⁴, 1946 онд дахин засварлан гаргасан⁵ бөгөөд тухай бүртээ зассан нь дүрмийг тодруулах зорилго агуулж байсныг, дүрэм бүхэлдээ “зөв” болоогүйг зохиогч бичжээ.⁶ Гэвч

² Ц. Дамдинсүрэн, Б. Осор, *Монгол үсгийн дүрмийн толь*, Улаанбаатар, 1983, 408 дугаар тал.

³ “Аливаа авианы бичиг дэх зөв бичих дүрмийн нийлбэр цогцыг зөв бичих зүй” гэдгээс кирилл бичиг авианы бичиг мөний хувьд англи хэлнээ “orthography”, франц хэлнээ “orthographe”, орос хэлнээ “орфография”, герман хэлнээ “rechtschreibung” хэмээдэг “зөв бичих зүй”-тэй байх ёстой. Кирилл бичгийн тухайд, “зөв бичих зүй”, “үсгийн дүрэм” гэсэн хоёр нэрийг хольцон хэрэглэсээр иржээ. “*Үсгийн дүрэм*” хэмээх нэр томъёо нь утга үсэгт улс үндэстний бичиг үсэгт байдаг, нангиад ханз нь 字法 болохыг Б. Ринчен, *Монгол бичгийн хэлний зүй*, Гутгаар дэвтэр, эрхэлсэн Э. Вандуй, Улаанбаатар, 1966, 89-р тал, Ч. Догсүрэнгийн 1986, 5-р сарын 26-нд Орчин цагийн монгол хэлний зөв бичих зүйг боловсронгуй болгох комисст гаргасан санал, Д.Уртнасан, *Монгол хэлний зөв бичих зүйн толины тухай*, Монгол хэл шинжлэл, Боть, VI (XXVIII), 9-р дэвтэр, Улаанбаатар, 2001, 170-184 –р тал, Ц. Шагдарсүрэн, *Эх хэлээ эвдэхгүй юм сан*, Улаанбаатар, 2007, 61-р тал зэргээс тодруулан үзнэ үү.

⁴ Ц. Дамдинсүрэн, *Монгол шинэ үсгийн дүрэм*, Улаанбаатар, 1942.

⁵ Ц. Дамдинсүрэн, *Монгол шинэ үсгийн товч дүрэм*, Улаанбаатар, 1946.

⁶ Үүнд, “...1942 оны дүрмээс 1946 оны дүрэм арай сайжирч нэг шат ахисан гэвэл одоогийн гурвадугаар удаагийн боловсруулж байгаа дүрэм урьдынхаас бас нэг шат ахисан гэж бодож байна. Гэхдээ бид түрүүчийн үсгийн дүрмийн үндсэн зүйлүүдийг өөрчилсөнгүй, зөвхөн тодорхой болгохыг л оролдлоо... Энэ удаагийн боловсруулсан дүрэмд дутуу дулим болсон зүйл үлэмжхэн байгаа...” хэмээжээ. Монгол улсын төрийн хэлний зөвлөл, *Монгол хэл бичиг*, II боть, Улаанбаатар, 2006, 49-50-р тал.

зохиогчийн “...Бид нэгмөсөн бүр боловсруулсан сайн дүрмийг зохиож чадахгүй тул алхам алхмаар шат ахиулсаар хожим бүр сайн дүрэмтэй болно гэж найдаж байна...”⁷ хэмээн бичсэний мөрөөр бололгүй, “1946 оны “Монгол шинэ үсгийн товч дүрэм нь орос үсэгт үндэслэсэн бичгийн зөв бичих зүйн үндэс болж цаашидаа 40 гаруй жил хэрэглэгдсэн ...”⁸ буюу үндсэндээ өнөөг хүртэл хэвшин тогтжээ.

Кирилл үсгийн дүрэм орчин цагийн монгол хэлний халх аялгууны байдлыг харгалзсан боловч монгол хэлний авианы байрлалын хуулийг бүрэн тусгаагүйн улмаас олон зохиомол дүрэмтэй, тэдгээр нь үгийн язгуур, үндэс, дагавар, нөхцөлийн бүтцийг бараг бүх тохиолдолд эвддэг болохыг, товчдоо уг үсгийн дүрэм монгол хэлний уугуул онцлог, жинхэнэ зүй тогтолд тохирохгүй байгааг Б. Ринчен, Ш. Лувсанвандан, Я. Цэвэл, Э. Вандуй, Б. Содном, А. Лувсандэндэв, Н. Жамбалсүрэн, Ц. Соном-юнрэн, Цэрэндулма, Д. Чойжалсүрэн, Н. Надмид, Т. Пагва, Чой, Лувсанжав, Д. Төмөртогоо, Ц. Шагдарсүрэн, Ш. Чоймаа, Л. Мишиг, Б. Цыдэндамбаев, Н. С. Трубецкой, П. Аалто, Чингэлтэй, Эрдэнэтогтох нараас эхлэн дотоод, гадаадын олон эрдэмтэн удаа дараа дурдсаар ирсэн билээ. Үүнийг өгүүлэхийн учир бол, одоог хүртэл хүчинтэй буй кирилл үсгийн дүрмийг мөрдсөн⁹ бөгөөд үүний дагууд боловсруулахад олон зүйл бэрхшээл тохиолддогийн гол шалтгааныг¹⁰ илтгэх гэсэн хэрэг билээ.

Нэр үгийн бүлэг

Кирилл үсгийн дүрмээр нэрийн хувилах бүлэг 32. Эдгээр бүлэг нь эгшгийн зохицлоос хамааран 4 хүртэл хуваагдана. Ижил бүлгийн дугаартай үгсийн хувилал адил гэсэн үг юм.

Дашрамд дурдахад тухайн үг олон тоонд хэрхэн хувирахыг үгийн санд тусгайлан зааж өгсөн болно. Учир нь, *нар, сар, дэлхий* гэх мэт цор ганц байдаг үгс олон тоонд хувилахгүй; *монголчууд, бүсгүйчүүд, хөгшчүүл, ноход, нөхөд, багш нар, залуус* зэрэг зарим үгс хамгийн идэвхтэй хэрэглэгддэг “-ууд, үүд”-ээс бусад залгавар бүтээврээр хувилж олон тоогоо илтгэдэг; мөн зарим нь *ноход, нохос, залуучууд, залуус* гэхчлэн хоёр түүнээс дээш олон тооны залгавар бүтээвр авах чадамжтай байдгийг тооцсон хэрэг. Хэдийгээр “-ууд, үүд”-ээс бусад олон тооны бүтээврийн үг бүтээх дагаврын шинжийг, ахиулбал тэдгээрээр хувилсан үгийн тоо харьцангуй цөөнийг харгалзан, тус бүрийг нэг үгэнд тооцон үгийн санд хадгалах аргаар шийдэх нь

⁷ Монгол улсын төрийн хэлний зөвлөл, *Монгол хэл бичиг*, II боть, Улаанбаатар, 2006, 50-р тал.

⁸ Ц. Шагдарсүрэн, *Монголчуудын үсэг бичгийн товчоон*, Улаанбаатар, 2001, 190-р тал.

⁹ Кирилл бичгийн зөв бичихзүйн анхны толь бичгээс хойш, Ц. Дамдинсүрэн, Я. Цэвэл, *Үсгийн дүрмийн зөв бичих толь*, Улаанбаатар, 1951; С. Мөөмөө, *Зөв бичих дүрмийн толь*, Улаанбаатар, 1960; Б. Осор, Б. Эрдэнэбаяр, *Зөв бичих зүйн дүрмээр зүйлчилсэн толь*, Улаанбаатар, 1973; Х. Далхжав, Ц. Цэрэнчимэд, *Зөв бичих зүйн толь бичиг*, Улаанбаатар, 1974; Ж. Баянсан, *Зөв бичих дүрмийн лавлах*, Улаанбаатар, 1980; Ц. Сүхбаатар, Ж. Лувсандорж, *Зөв бичих зүйн лавлах*, Улаанбаатар, 1983; Ц. Дамдинсүрэн, Б. Осор, *Монгол үсгийн дүрмийн толь*, 1983; Г. Доржханд, *Зөв бичих толь, эх сэдвүүд IV-VIII*, Улаанбаатар, 1999; *Зөв бичих зүйн зарын авлага*, Улсын багшийн коллеж, Улаанбаатар, 2000; Ц. Оюун, *Зөв бичих дүрмийн тогтолцоот хураамж*, Улаанбаатар, 2000; Л. Болд, *Монгол хэлний зөв бичихзүйн толь*, Улаанбаатар, 2003 зэрэг олон толь бичгүүд хэвлэгдсэн болно.

Бүх зөв бичихзүйн толь бичгүүд бие биеэ ямар нэг талаар нөхсөн шинжтэй боловч цөөнгүй үгсийг дор бүрнээ харилцан адилгүйгээр журамласан нь багагүй төвөг, эргэлзээ учруулах нь бий. Бид Ц. Дамдинсүрэн, Б. Осор нарын 1983 онд хэвлүүлсэн толь бичгийг голлон барилаа.

¹⁰ Монгол хэлний зүй тогтлоос зөрсөн дүрмээс шалтгаалсан бэрхшээлийн талаар үгийн бүлгийн тайлбар хэсгээс тодруулан үзнэ үү.

хөрвүүлэх програмын тухайд байж болох ч цааш үгийн бүтцээр задалж, зөв бичлэг шалгах програм (spelling check) ажиллах үед үгийн бүтцийг бүрэн задалж чадахгүй, хэрэглэгчид дутмаг мэдээлэл өгөх зэрэг хүндрэлд хүргэнэ.

32 бүлгийг тус бүрийн онцлогоор задлан тайлбарлавал,

1. Эгшигт гийгүүлэгчээр төгссөн, балархай эгшиггүй, үндсэнд “н” гардаггүй үгс: Нэрийн нөхцөлийг эгшгийн зохицлыг харгалзан шууд залгана.

Жишээ: 1.1 санал, цуврал 1.2 ном, бодрол
1.3 хөл, өмсгөл 1.4 бэр, дэглэм

саналууд, саналын, саналд, саналыг, саналаас, саналаар, саналтай, санал руу, саналаа, санал минь, санал чинь, санал нь

2. “н” – ээр төгссөн, балархай эгшиггүй, үндсэнд “н” гарахгүй: Харьяалахын тийн ялгалд “-ы, ий” гэсэн хэлбэрийг авна.

Жишээ: 2.1 ачтан, дуган 2.2 отгон, тосгон
2.3 өвчтөн, хөдөлгөөн 2.4 хүчтэн, тэмцээн

тэмцээнүүд, тэмцээний, тэмцээнд, тэмцээнийг, тэмцээнээс, тэмцээнээр, тэмцээнтэй, тэмцээн рүү, тэмцээнээ, тэмцээн минь, тэмцээн чинь, тэмцээн нь

3. Заримдаг гийгүүлэгчээр төгссөн, балархай эгшиггүй, үндсэнд “н” гардаггүй үгс: Өгөх оршихын тийн ялгалын “-д” хэлбэрийг залгахад зохих эгшгийг жийрэглэнэ.

Жишээ: 3.1 ахмад, угсралт 3.2 тоглолт, холбоц
3.3 нөөц, цөөнх 3.4 бүргэд, шүүх

ахмадууд, ахмадын, ахмадад, ахмадыг, ахмадаас, ахмадаар, ахмадтай, ахмад руу, ахмадаа, ахмад минь, ахмад чинь, ахмад нь

4. “ж, ч, ш”-ээр төгссөн, балархай эгшиггүй, үндсэнд “н” гардаггүй үгс: Үгийн эр, эмийг үл харгалзан харьяалах, заахын тийн ялгалд “-ийн, -ийг” гэсэн хэлбэрийг залгаж, өгөх оршихын тийн ялгалд “и” жийрэглэнэ.

Жишээ: 4.1 шавж, сурвалж 4.2 боломж, хормогч
4.3 хори, төхөөрөмж 4.4 хүлэмж, гийгүүлэгч

сурвалжууд, сурвалжийн, сурвалжид, сурвалжийг, сурвалжаас, сурвалжаар, сурвалжтай, сурвалж руу, сурвалжаа, сурвалж минь, сурвалж чинь, сурвалж нь

5. Балархай эгшиггүй, үндсэнд “н” гардаггүй үгс буюу монгол бичигт дүйцэх нь хатуу дэвсгэрээр төгссөн үгс¹¹: Өгөх оршихын тийн ялгалын “т” хэлбэрийг шууд залгадгаараа ялгарна.

Жишээ: 5.1 хязгаар, дохиур 5.2 ёзоор, зовхис
5.3 өглөг, төлбөр 5.4 үлгэр, цэцэрлэг

үлгэрүүд, үлгэрийн, үлгэрт, үлгэрийг, үлгэрээс, үлгэрээр, үлгэртэй, үлгэр рүү, үлгэрээ, үлгэр минь, үлгэр чинь, үлгэр нь

6. “т” гийгүүлэгчээр төгссөн, ялгах эгшиггүй, балархай эгшиггүй үгс: Үгийн эрийг үл харгалзан харьяалах, заахын тийн ялгалд “-ийн, -ийг” гэсэн хэлбэрийг залгаж, өгөх оршихын тийн ялгалд “т” залгана. 6.3, 6.4 гэж оноох шаардлагагүй. Учир нь, үүнд хамаарч болох э, ө эгшиг бүхий үгс 5.3, 5.4-тай ижил.

Жишээ: 6.1 баг, уртраг 6.2 олбог, хоног

¹¹ Монгол бичгийн хатуу дэвсгэр гийгүүлэгчээр төгссөн үгсийн хувилалтай дүйх учиртай бүлэг. Гэсэн хэдий ч кирилл үсэгт эгшгээр төгссөн олон үгийн эцэсийн эгшгийг тэмдэглэлгүй журамласан учир тус бүлэгт угтаа эгшгээр төгссөн үгс цөөнгүй багтсан болно.

хоногууд, хоногийн, хоногид, хоногийг, хоногоос, хоногоор, хоногтой, хоног руу, хоногоо, хоног минь, хоног чинь, хоног нь

7. Туслах эгшгээр төгссөн үгс: Харьяалах, заахын тийн ялгалаас бусад урт эгшгээр эхэлсэн нөхцөл залгахад нэг эгшгийг гээж бичнэ.

Жишээ: 7.1 ая 7.2 гоё 7.4 үе

үеүд, үеийн, үед, үеийг, үеэс, үеэр, үетэй, үе рүү, үеэ, үе минь, үе чинь, үе нь

8. Богино “и”-ээр төгссөн үгс: Урт эгшгээр эхэлсэн бүх залгавар нөхцөл залгахад нэг эгшгийг гээж бичнэ.

Жишээ: 8.1 анги, занги 8.2 колони, онги
8.3 сөрви 8.4 энерги

ангиуд, ангийн, ангид, ангийг, ангиас, ангиар, ангитай, анги руу, ангиа, анги минь, анги чинь, анги нь

9. Үгийн үндсэнд “н” гардаг¹², балархай эгшиггүй үгс: Заах, үйлдэх, хамтрах, чиглэхийн тийн ялгал, хамаатуулахын нөхцөлийг шууд, нэрийн бусад нөхцөлийг залгахад “н” гарч, өгөх оршихын тийн ялгалд зохих эгшгийг бас жийрэглэнэ.

Жишээ: 9.1 бургас, хад 9.2 мод, ёс
9.3 өд, мөс 9.4 нүд, сүлжээс

бургаснууд, бургасны, бургасанд, бургасыг, бургаснаас, бургасаар, бургастай, бургас руу, бургасаа, бургас минь, бургас чинь, бургас нь

10. Өмнөх бүлгээс ялгарах нь заахын тийн ялгалд эм үгийн “-ийг” хэлбэрийг авна.

Жишээ: 10.1 банк, танк

банкнууд, банкны, банкинд, банкиг, банкнаас, банкаар, банктai, банк руу, банкаа, банк минь, банк чинь, банк нь

11. “ж, ч, ш”-ээр төгссөн, үндсэнд “н” гардаг, балархай эгшиггүй үгс: 4-р бүлгээс “н” гардгаараа ялгарна.

Жишээ: 11.1 анааш, хайч 11.2 дош, цоож
11.3 бөгж, нөөш 11.4 гинж, сэмж

бөгжнүүд, бөгжний, бөгжинд, бөгжийг, бөгжнөөс, бөгжөөр, бөгжтэй, бөгж рүү, бөгжөө, бөгж минь, бөгж чинь, бөгж нь

12. Урт эгшгээр төгссөн үгс: олон тоо, харьяалах, өгөх орших, гарахын тийн ялгалд нөхцөлийн “н” бүхий хэлбэрийг, заахын тийн ялгалд “г” хэлбэрийг, үйлдэх, эзэнд хамаатуулах нөхцөлд “г” жийрэглэнэ.

Жишээ: 12.1 авиа, даавуу 12.2 болзоо, овоо
12.3 бөглөө, өвөлжөө 12.4 гэрчилгээ, өвчүү

болзоонууд, болзооны, болзоонд, болзоог, болзооноос, болзоогоор, болзоотой, болзоо руу, болзоогоо, болзоо минь, болзоо чинь, болзоо нь

13. Богино “и”-ээр төгссөн, нууц “н” бүхий үгс: 8-р бүлгээс үндсэнд “н” гардгаараа ялгарна.

Жишээ: 13.1 уушги, тархи 13.2 горхи, борви

тархинууд, тархины, тархинд, тархийг, тархинаас, тархиар, тархитай, тархи руу, тархиа, тархи минь, тархи чинь, тархи нь

14. Үндсэнд “н” гардаггүй бүлгээс өгөх оршихын тийн ялгалын хувиллаар ялгарна.

¹² Эртний монгол хэлний, хэлний үзүүрийн “н”-ээр төгссөн нэр үгсийн аймагт багтах үгсийн дотроос нэг хэсэг нь орчин цагийн монгол хэлэнд эцсийн “н”-ээ тогтвортой хадгалж, нөгөө хэсэг нь зарим байдалд “н”-ээ гэж, зарим тохиолдолд хадгалж байдаг. “н” нь тогтвортой эсэхийн нэг шалгуурыг тийн ялгалаар хувилгах гэж хэлж болно.

Жишээ: 14.1 *хайр*

хайрууд, хайрын, хайранд, хайрыг, хайраас, хайраар, хайртай, хайр руу, хайраа, хайр минь, хайр чинь, хайр нь

15. Хос эгшгээр төгссөн үгс¹³: 12-р бүлгээс харьяалахын тийн ялгалд “-н, -г”, өгөх оршиход “-д” авдгаараа ялгаатай.

Жишээ: 15.1 *гахай, дугтуй* 15.2 *могой, овоохой*

15.3 *өехий, өлгий* 15.4 *эрвээхий, цэцгий*

дугтуйнууд, дугтуйн, дугтуйнд, дугтуйг, дугтуйнаас, дугтуйгаас, дугтуйгаар, дугтайтай, дугтуй руу, дугтуйгаа, дугтуй минь, дугтуй чинь, дугтуй нь

16. Хамрын “н”-ээр төгссөн үгс: Зарим тохиолдолд “г” жийрэглэнэ.

Жишээ: 16.1 *сан, шаазан* 16.2 *орчлон, ёотон*

16.3 *хөвөн, зөн* 16.4 *дүн, үзэсгэлэн*

сангууд, сангийн, санд, санг, сангаас, сангаар, сантай, сан руу, сангаа, сан минь, сан чинь, сан нь

17. Эгшигт гийгүүлэгчээр төгссөн, балархай эгшигтэй үгс¹⁴: 1-р бүлгээс балархай эгшгээрээ ялгарна.

Жишээ: 17.1 0. *арал, мандал* 1. *арл-, мандл-*

17.2 0. *ноёрхол, бодол* 1. *ноёрхл-, бодл-*

17.3 0. *цөөрөм, нөлөөлөл* 1. *цөөрм-, нөлөөлл-*

17.4 0. *үнэмшил, өгүүлэл* 1. *үнэмшил-, өгүүлл-*

арлууд, арлын, аралд, арлыг, арлаас, арлаар, аралтай, арал руу, арлаа, арал минь, арал чинь, арал нь

18. “и”-ээс бусад богино эгшгээр төгссөн үгс: Эгшиг нь голчлон ялгах эгшиг байна. Үндсийн 2 хэлбэртэй.

Жишээ: 18.1 0. *арга, аварга* 1. *арг-, аварг-*

18.2 0. *соёмбо, зорилго* 1. *соёмб-, зорилг-*

18.3 0. *шөнө, бөөрөлзгөнө* 1. *шөн-, бөөрөлзгөн-*

18.4 0. *тэмээлзгэнэ, цээнэ* 1. *тэмээлзгэн-, цээн-*

¹³ Кирилл үсгийн дүрэмд хос эгшгээр төгссөн нэр үгийн араас гарахын тийн ялгалын нөхцөлийг залгахад “г” гийгүүлэгч жийрэглэн малгай → малгайгаас, орой → оройгоос, зай → зайгаас гэхчлэн бичихээр заажээ. Энэ нь маргаангүй монгол хэлний зүйд нийцсэн бичлэг мөн.

Гэвч, эдүгээ нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд бичиж, аман ярианд хэлэлцэн буйгаас үзэхэд, “г” жийргийн хажуугаар, “н” жийргийг хэрэглэх нь түгээмэл болжээ. Энэхүү ярианы хэлний “-(н)аас, -(н)оос, -(н)өөс, -(н)ээс” хэлбэр нь хос эгшгээр төгссөн үгийн харьяалахын тийн ялгалт толгойн, малгайн, оройн гэх мэт хэлбэрээс халтиран, нөгөө талаар тогтворгүй “н”-тэй үндэс бүхий үгсийн “хуурмаг” адилтгалаар гарч иржээ. Гэхдээ шалтгаан нь хэлний хэмнэх зарчмаас үүдэлтэй бололтой. Угтаа малгайн чинээнээс, толгойн дайнаас гэх мэтээр овор хэмжээ, их багын зүйлийг харьцуулан жишсэн задлаг хэлбэрийг хэлэхүйд хурааж малгайнаас том, толгойноос бага гэх мэтээр хэлэх болсон байна. Энэ нь яваандаа зөвхөн тэмдэг нэрийн харьцуулсан зэрэг ч бус, ерөөс хос эгшгээр төгссөн үгийн гарахын тийн ялгалын хэлбэр бүхий бүх л тохиолдолд хамаарах болжээ. Гэтэл, үйлдэхийн тийн ялгалаар хэлбэржихдээ малгайнаар, толгойноор гэдэггүй атлаа гагц гарахын тийн ялгал дээр гарч ирээд байдгийн учир нь үүнд байх шиг байна. Ийм хэлзүйн үг бичгийн хэлэнд ч нэвтэрсэн байх тул компьютерээр хөрвүүлэг хийх зорилгоос шалтгаалан -(н)аас, -(г)аас хоёр хэлбэрийг сонгох боломжтойгоор орууллаа.

¹⁴ Үндсийн хэлбэр нь балархай эгшигтэй үгсийн тухайд 0 болон 1 гэсэн утгатай. 0 хэлбэр нь балархай эгшиг бүхий хэлбэр, 1 нь балархай эгшгээ гэсэн хэлбэр болно. Жишээлбэл, бодол – 0 хэлбэр, бодл- 1 хэлбэр. Тийн ялгалаас өгөх орших, хамтрах, чиглэхийн нөхцөл, биед хамаатуулах нөхцөл 0 хэлбэрт (*бодол-д, бодол-той, бодол-руу, бодол минь, бодол чинь, бодол нь*), олон тоо, харьяалах, заах, гарах, үйлдэхийн тийн ялгал, эзэнд хамаатуулах нөхцөл 1 хэлбэрт (*бодл-ууд, бодл-ын, бодл-ыг, бодл-оос, бодл-оор, бодл-оо*) тус тус залгагдана.

аваргууд, аваргын, аваргад, аваргыг, аваргаар, аваргатай, аварга руу, аваргаа, аварга минь, аварга чинь, аварга нь

19. Заримдаг гийгүүлэгчээр төгссөн, балархай эгшигтэй үгс: 3-р бүлгээс балархай эгшгээрээ ялгарна.

Жишээ:	19.1	0. <i>бусад, тархац</i>	1. <i>бусд-, тархи-</i>
	19.2	0. <i>тогтоц, олдоц</i>	1. <i>тогтц-, олдц-</i>
	19.3	0. <i>дөхөц, дөчит</i>	1. <i>дөхц-, дөчт-</i>
	19.4	0. <i>бүтэц, хүүхэд</i>	1. <i>бүтц-, хүүхд-</i>

хүүхдүүд, хүүхдийн, хүүхдэд, хүүхдийг, хүүхдээс, хүүхдээр, хүүхэдтэй, хүүхэд рүү, хүүхдээ, хүүхэд минь, хүүхэд чинь, хүүхэд нь

20. “н”-ээр төгссөн, балархай эгшигтэй үгс: 2-р бүлгээс мөн балархай эгшгээрээ ялгарна.

Жишээ:	20.1	0. <i>майхан, дайсан</i>	1. <i>майхн-, дайсн-</i>
	20.2	0. <i>морьтон, орон</i>	1. <i>морьтн-, орн-</i>
	20.3	0. <i>өвчин, өстөн</i>	1. <i>өвчн-, өстн-</i>
	20.4	0. <i>сүжигтэн, түмэн</i>	1. <i>сүжигтн-, түмн-</i>

орнууд, орны, оронд, орныг, орноос орноор, оронтой, орон руу, орноо, орон минь, орон чинь, орон нь

21. 5-р бүлгээс балархай эгшгээрээ ялгарна.

Жишээ:	21.1	0. <i>баатар, газар</i>	1. <i>баатр-, газр-</i>
	21.2	0. <i>сондор, дотор</i>	1. <i>сондр-, дотр-</i>
	21.3	0. <i>зөрөг, мөндөр</i>	1. <i>зөрг-, мөндр-</i>
	21.4	0. <i>мэдүүлэг, сүүдэр</i>	1. <i>мэдүүлг-, сүүдр-</i>

баатрууд, баатрын, баатарт, баатрыг, баатраас, баатраар, баатартай, баатар руу, баатраа, баатар минь, баатар чинь, баатар нь

22. 6-р бүлгээс балархай эгшгээр ялгарна.

Жишээ:	22.1	0. <i>таамаг, ураг</i>	1. <i>таамг-, ург-</i>
	22.2	0. <i>цомог, домог</i>	1. <i>цомг-, домг-</i>

цомгууд, цомгийн, цомогт, цомгийг, цомгоос, цомгоор, цомогтой, цомог руу, цомгоо, цомог минь, цомог чинь, цомог нь

23. “Эгшигт гийгүүлэгч+зөөлний тэмдэг”-ээр төгссөн үгс¹⁵:

Жишээ:	23.1	0. <i>сонгууль, хань</i>	1. <i>сонгуули-, хани-</i>
	23.2	0. <i>лооль, говь</i>	1. <i>лооли-, гови-</i>
	23.4	0. <i>дизель, мебель</i>	1. <i>дизели-, мебели-</i>

говууд, говийн, говьд, говийг, говиос, говиор, говьтой, говь руу, говио, говь минь, говь чинь, говь нь

24. “Заримдаг гийгүүлэгч + зөөлний тэмдэг”-ээр төгссөн үгс:

Жишээ:	24.1	0. <i>тахь, задь</i>	1. <i>тахи-, зади-</i>
	24.2	0. <i>боть, тохь</i>	1. <i>боти-, тохи-</i>

ботиуд, ботийн, ботид, ботийг, ботиос, ботиор, ботитой, боть руу, ботио, боть минь, боть чинь, боть нь

25. 18-р бүлгээс үндсэнд “н” гарч ирдгээрээ ялгарна.

¹⁵ Үндсийн хэлбэр нь зөөлний тэмдгээр төгссөн үгсийн тухайд 0 болон 1 гэсэн утгатай. 0 хэлбэр нь зөөлний тэмдэг бүхий хэлбэр, 1 нь зөөлний тэмдэг “и” болсон хэлбэр болно. Жишээлбэл, *говь* – 0 хэлбэр, *говви* – 1 хэлбэр. Тийн ялгалаас өгөх орших, хамтрах, чиглэхийн нөхцөл, биед хамаатуулах нөхцөл 0 хэлбэрт (*говь-д, говь-той, говь-руу, говь-минь, говь-чинь, говь-нь*), олон тоо, харьяалах, заах, гарах, үйлдэхийн тийн ялгал, эзэнд хамаатуулах нөхцөл 1 хэлбэрт (*говви-уд, говви-йн, говви-йг, говви-ос, говви-ор, говви-о*) тус тус залгагдана.

Жишээ:	25.1	0. <i>тамга, унага</i>	1. <i>тамг-, унаг-</i>
	25.2	0. <i>торго, ломбо</i>	1. <i>торг-, ломб-</i>
	25.3	0. <i>мөнгө, өнгө</i>	1. <i>мөнг-, өнг-</i>
	25.4	0. <i>илбэ, мэнгэ</i>	1. <i>илб-, мэнг-</i>

өнгөнүүд, өнгөний, өнгөнд, өнгийг, өнгөнөөс, өнгөөр, өнгөтэй, өнгө рүү, өнгөө, өнгө минь, өнгө чинь, өнгө нь

26. 19-р бүлгээс үндсэнд “н” гарч ирдгээрээ ялгарна.

Жишээ:	26.1	0. <i>шандас, хувцас</i>	1. <i>шандс-, хувцс-</i>
	26.2	0. <i>тором, холтос</i>	1. <i>торм-, холтс-</i>
	26.3	0. <i>гөлөм, өндөг</i>	1. <i>гөлм-, өндг-</i>
	26.4	0. <i>тэрэг, гэдэс</i>	1. <i>тэрг-, гэдс-</i>

тэрэгнүүд, тэргэний, тэргэнд, тэргийг, тэргэнээс, тэргээр, тэрэгтэй, тэрэг рүү, тэргээ, тэрэг минь, тэрэг чинь, тэрэг нь

27. 11-р бүлгээс балархай эгшгээрээ ялгарна.

Жишээ:	27.1	0. <i>таташ, нухаш</i>	1. <i>тати-, нухи-</i>
	27.2	0. <i>тохош</i>	1. <i>тохи-</i>
	27.4	0. <i>идэш, хэвтэш</i>	1. <i>иди-, хэвти-</i>

нухашнууд, нухашны, нухшинд, нухшийг, нухашнаас, нухшаар, нухаштай, нухаш руу, нухшаа, нухаш минь, нухаш чинь, нухаш нь

28. 23-р бүлгээс үндсэнд “н” гардгаараа ялгаатай.

Жишээ:	28.1	0. <i>унь, завь,</i>	1. <i>уни-, зави-</i>
	28.2	0. <i>зоорь, ооль</i>	1. <i>зоори-, ооли-</i>

унинууд, унины, унинд, унийг, унинаас, униар, уньтай, унь руу, униа, унь минь, унь чинь, унь нь

29. 24-р бүлгээс үндсэнд “н” гардгаараа ялгаатай.

Жишээ:	29.1	0. <i>бахь, даахь</i>	1. <i>бахи-, даахи-</i>
	29.2	0. <i>бохь, тоть</i>	1. <i>бохи-, тоти-</i>

тотинууд, тотины, тотинд, тотийг, тотиноос, тотиор, тотитой, тоть руу, тотио, тоть минь, тоть чинь, тоть нь

30. Урт эшгээр төгссөн үгс: 12-р бүлгээс харьяалах, гарах, үйлдэх, эзэнд хамаатуулах нөхцөл залгахад “г” жийрэглэх, өгөх орших, чиглэх, биед хамаатуулах нөхцөлийг шууд залгадгаараа ялгарна.

Жишээ:	30.1	<i>булиа, чалчаа</i>	30.2	<i>ондоо, мохоо</i>
	30.3	<i>гөлрөө, мөлхөө</i>	30.4	<i>эргүү</i>

булианууд, булиагийн, булиад, булиаг, булиагаас, булиагаар, булиатай, булиа руу, булиагаа, булиа минь, булиа чинь, булиа нь

31. 4-р бүлгээс балархай эгшгээрээ ялгарна.

Жишээ:	31.1	0. <i>дундач, бутач</i>	1. <i>дундч-, бутч-</i>
	31.2	0. <i>голдоч, модоч</i>	1. <i>голдч-, модч-</i>
	31.4	0. <i>үдэш</i>	1. <i>үдш-</i>

үдшүүд, үдшийн, үдшид, үдшийг, үдшээс, үдшээр, үдэштэй, үдэш рүү, үдшээ, үдэш минь, үдэш чинь, үдэш нь

32. “вч” дагавраар төгссөн үгс¹⁶:

¹⁶ “вч” дагавраар төгссөн үгсийг тусгайлан бүлэглэсний учир нь үгсийн дүрэмд “-вч” дагавраар бүтсэн нэр үгийг харьяалах ба өгөх оршихын тийн ялгалаар хэлбэржүүлэхдээ -ийн, -(и)д хэлбэрийг залгана хэмээснийг дагахын хамт, бодит хэрэглээнд тогтворгүй “н” бүхий үгсийн адилаар хувилах нь түгээмэл болсныг харгалзан, мөн монгол хэлний зүй тогтлоор гийгүүлэгчээр төгссөн үгийн үндсэнд “н” гарахгүй, эгшгээр төгссөн үгийн үндсэнд “н” гарах боломжтой тул энэ бүлэгт харгалзах залгавар

Жишээ: 32.1 саравч, хуруувч 32.2 тохойвч, оройвч
 32.3 өндгөвч, зөөлөвч 32.4 үүргэвч, хэтэвч
 саравнууд, саравчууд, саравчны, саравчийн, саравчинд, саравчид, саравчийг,
 саравчнаас, саравчаас, саравчаар, саравчтай, саравч руу, саравчаа, саравч
 минь, саравч чинь, саравч нь

Кирилл үсгийн дүрмээр бүх нэр үг хувиллаараа дээрх 32 зүйлд багтана.

Үйл үгийн бүлэг

Кирилл үсгийн дүрмээр үйлийн хувилах бүлэг 16. Үгийн бүлэг нь мөн эгшгийн зохицлоос хамааран 4 хүртэл хуваагдана.

1. Урт эгшгээр төгссөн үгс: Урт эгшгээр эхэлсэн нөхцөл залгахад “г” жийрэглэнэ.

Жишээ: 1.1 асуу-, бай- 1.2 боо-, зохио-
 1.3 ерөө-, нөө- 1.4 нээ-, хүлээ-
 асууж¹⁷, асуугаад, асуун, асуусаар, асуувч, асуумагц, асуутал, асуухлаар,
 асуувал, асууваас, асуумаажин, асуумааж, асуунгуут, асуугуут, асуунгаа,
 асуулгүй, асуухул, асууруун

2. Богино “и”, туслах эгшгээр төгссөн үгс: Урт эгшгээр эхэлсэн нөхцөл залгахад урт эшгийн нэгийг хасаж бичнэ.

Жишээ: 2.1 нарги-, уя- 2.2 дорги-, оё- 2.4 хэе-
 уяж, уяад, уян, уясаар, уявч, уямагц, уятал, уяхлаар, уявал, уяваас, уямаажин,
 уямааж, уянгуут, уяут, уянгаа, уялгүй, уяхул, уяруун

3. “м, н, л, в”-ээс бусад буюу “р, г” эгшигт гийгүүлэгчээр төгссөн үгс¹⁸: Дан гийгүүлэгчээс бүтсэн болон давхар гийгүүлэгчээр эхэлсэн нөхцөл залгахад эгшиг жийрэглэнэ.

Жишээ: 3.1 зур-, хур- 3.2 ор-, нор-
 3.3 өр-, сөр- 3.4 түг-, ир-
 зурж, зураад, зуран, зурсаар, зуравч, зурмагц, зуртал, зурахлаар, зурвал,
 зурваас, зурмаажин, зурмааж, зурангуут, зуруут, зурангаа, зуралгүй, зурахул,
 зурруун

4. “м, л, в” эгшигт гийгүүлэгчээр төгссөн үгс: 3-р бүлгээс ялгарах нь “вал⁸, ваас⁸” нөхцөлийн “бал⁴, баас⁴” хэлбэрийг авна.

Жишээ: 4.1 хам-, сал- 4.2 бол-, зов-
 4.3 хөв-, өнгөл- 4.4 хэл-, энэл-
 болж, болоод, болон, болсоор, боловч, болмогц, болтол, болохлоор, болбол,
 болбоос, болмоожин, болмоож, болонгуут, болуут, болонгоо, бололгүй,
 болохул, болруун

бүтээврийн олонлогийг “н” агуулсан болон агуулаагүй гэсэн хоёр бүрэлдэхүүнтэйгээр гаргав. Орчин цагийн монгол хэлэнд ой хөвчийн мод, нумын хөвчний уяа, тугалын хүзүүвчнээс татах, уулын хүзүүвчээс харах гэх зэргээр утгын ялгааг нь гарган хэлэлцэх нь цөөнгүй болжээ.

¹⁷ Үйлийн хувилал багагүй учир хэмнэхийн үүднээс жишээг “нөхцөлдүүлэн холбох нөхцөл”-өөр төлөөлүүлэв.

¹⁸ Өнгөн талдаа 5-р бүлэгтэй ижил мэт боловч тусгайлан бүлэг болсны учир нь гийгүүлэгчээр төгссөн бичихээр журамласан болохоос монгол бичгийн хэлэнд эгшгээр төгсдөг үгс тул 5-р бүлгээс өөр хувилалтай.

5. Эгшигт гийгүүлэгчээр төгссөн үгс¹⁹: Тус бүлгийн эгшигт гийгүүлэгч нь монгол бичгийн хатуу дэвсгэр гийгүүлэгчтэй дүйнэ. 3-р бүлгээс ялгарах нь нөхцөлдүүлэн холбохын зэрэгцэхийн “ч”, цагаар төгсгөхийн “чээ” хэлбэрийг авна.

Жишээ: 5.1 захир-, сур- 5.2 тохир-, тонгор-
5.3 өг-, хөөр- 5.4 гэгээр-, хүр-

хүрч, хүрээд, хүрэн, хүрсээр, хүрэвч, хүрмэгц, хүртэл, хүрэхлээр, хүрвэл, хүрвээс, хүрмээжин, хүрмээж, хүрэнгүүт, хүрүүт, хүрэнгээ, хүрэлгүй, хүрэхул, хүррүүн

6. “Эгшиг + заримдаг гийгүүлэгч”-ээр төгссөн үгс²⁰:

Жишээ: 6.1 албад-, дас- 6.2 бод-, бос-
6.3 дөх-, өс- 6.4 нис-, бүт-

нисэж, нисээд, нисэн, ниссээр, нисэвч, нисмэгц, нистэл, нисэхлээр, нисвэл, нисвээс, нисмээжин, нисмээж, нисэнгүүт, нисүүт, нисэнгээ, нисэлгүй, нисэхул, нисрүүн, ниснэ

7. “Гийгүүлэгч + заримдаг гийгүүлэгч”-ээр төгссөн үгс: 6-р бүлгээс ялгарах нь одоо ба ирээдүй цагаар төгсгөх “-на”⁴ нөхцөлийг залгахад зохих эгшигийг жийрэглэнэ.

Жишээ: 7.1 ханд-, тарх- 7.2 холд-, зогс-
7.3 мөрд-, төгс- 7.4 тэмц-, бэрт-

зогсож, зогсоод, зогсон, зогссоор, зогсовч, зогсмогц, зогстол, зогсохлоор, зогсвол, зогсвоос, зогсмоожин, зогсмоож, зогсонгуут, зогсуут, зогсонгоо, зогсолгүй, зогсохул, зогсоруун, зогсоно

8. “Эгшиг + “ж, ч, ш” гийгүүлэгч”-ээр төгссөн үгс:

Жишээ: 8.1 ухааж-, хааш- 8.2 оч-, бойж-
8.3 өргөж-, өч- 8.4 идээш-, биеж-

өчиж, өчөөд, өчин, өчсөөр, өчивч, өчмөгц, өчтөл, өчихлөөр, өчвөл, өчвөөс, өчмөөжин, өчмөөж, өчингүүт, өчүүт, өчингөө, өчилгүй, өчихул, өчрүүн, өчнө

9. “Гийгүүлэгч + “ж, ч, ш” гийгүүлэгч”-ээр төгссөн үгс: 8-р бүлгээс ялгарах нь одоо ба ирээдүй цагаар төгсгөх “-на”⁴ нөхцөлийг залгахад “и” эгшиг жийрэглэнэ.

Жишээ: 9.1 дамж-, гарш- 9.2 тогш-, огш-
9.3 хэвш-, зөвш- 9.4 дэвш-, түгш-

дэвшиж, дэвшээд, дэвшин, дэвшсээр, дэвшивч, дэвшмэгц, дэвштэл, дэвшихлээр, дэвшвэл, дэвшвээс, дэвшмээжин, дэвшмээж, дэвшингүүт, дэвшүүт, дэвшингээ, дэвшилгүй, дэвшихул, дэвшрүүн, дэвшинэ

10. “и”-ээс бусад богино эгшгээр төгссөн үгс: Урт эгшгээр эхэлсэн залгавар нөхцөл залгахад нэг эгшигийг гээж бичнэ. Үүнийг шийдэхдээ “үндсийн хэлбэр” ашиглав.

Жишээ: 10.1 0. дагна-, зарла- 1. дагн-, зарл-
10.2 0. орло-, оно- 1. орл-, он-
10.3 0. зөвлө-, сөнө- 1. зөвл-, сөн-
10.4 0. сэлгэ-, хэвлэ- 1. сэлг-, хэвл-

¹⁹ Угтаа монгол бичгийн хатуу дэвсгэрээр төгссөн үгсийн хувилалтай таарах бүлэг боловч үг бүрд оноох үед тус бүлэгт багтах цөөнгүй үгс монгол бичигт эгшгээр төгссөн байдаг. Өөрөөр хэлбэл, хүчинтэй мөрдөж буй кирилл үгсийн дүрмийг даган хатуу дэвсгэрээр төгссөн үгс, эгшгээр төгссөн үгсийг холилдуулан бүлэглэхээс өөр аргагүйд хүрсэн.

²⁰ Тус бүлэгт мөн 5-р бүлгийн адил хатуу, зөөлөн дэвсгэр холилдон орсон. Нис, бос зэрэг олон үгийг эгшгээр төгссөн үг мэт хувилгах болно. Жишээлбэл, зүй нь нисч, босч байх байтал дүрмийн дагуу нисэж, босож гэж бичдэг.

зарлж, зарлаад, зарлан, зарласаар, зарлавч, зарламагц, зарлатал, зарлахлаар, зарлавал, зарлаваас, зарламаажин, зарламааж, зарлангуут, зарлуут, зарлангаа, зарлалгүй, зарлахул, зарларуун

11. Эгшигт гийгүүлэгчээр төгссөн, балархай эгшигтэй үгс: Эгшигт гийгүүлэгч нь монгол бичгийн зөөлөн дэвсгэр гийгүүлэгчтэй дүйнэ.

Жишээ: 11.1 0. чандал-, батал- 1. чандл-, батл-
11.2 0. онцол-, довтол- 1. онцл-, довтл-
11.3 0. мөнхөл-, нөөцөл- 1. мөнхл-, нөөцл-
11.4 0. эмхэл-, нэхэмжил- 1. эмхл-, нэхэмжл-

онцолж, онцлоод, онцлон, онцолсоор, онцловч, онцолмогц, онцолтол, онцлохлоор, онцолбол, онцолбоос, онцолмоожин, онцолмоож, онцлонгуут, онцлуут, онцлонгоо, онцолгүй, онцлохул, онцолруун

12. Эгшигт гийгүүлэгчээр төгссөн, балархай эгшигтэй үгс: Эгшигт гийгүүлэгч нь монгол бичгийн хатуу дэвсгэр гийгүүлэгчтэй дүйнэ.

Жишээ: 12.1 0. амьдар-, сайжир- 1. амьдр-, сайжр-
12.2 0. боловсор-, тодор- 1. боловср-, тодр-
12.3 0. төвшир-, зөөлөр- 1. төвшр-, зөөлр-
12.4 0. илэр-, мэдэр- 1. илр-, мэдр-

мэдэрч, мэдрээд, мэдрэн, мэдэрсээр, мэдрэвч, мэдэрмэгц, мэдэртэл, мэдрэхлээр, мэдрэвэл, мэдэрвээс, мэдэрмээжин, мэдэрмээж, мэдрэнгүүт, мэдрүүт, мэдрэнгээ, мэдрэлгүй, мэдрэхул, мэдрэрүүн

13. “Эгшигт гийгүүлэгч + зөөлний тэмдэг”-ээр төгссөн үгс: Эгшигт гийгүүлэгч болон урт эгшгээр эхэлсэн залгавар нөхцөл залгахад зөөлний тэмдэг “и” болж өөрчлөгдөнө.

Жишээ: 13.1 0. барь-, тань- 1. бари-, тани-
13.2 0. боль-, хорь- 1. боли-, хори-

барьж, бариад, барин, барьсаар, баривч, баримагц, барьтал, барихлаар, баривал, бариваас, баримаажин, баримааж, барингуут, бариут, барингаа, барилгүй, барихул, барируун

14. “Заримдаг гийгүүлэгч + зөөлний тэмдэг”-ээр төгссөн үгс: 13-р бүлгээс ялгарах нь заримдаг гийгүүлэгчээр эхэлсэн залгавар нөхцөл залгахад зөөлний тэмдэг нь мөн “и” болон хувирна.

Жишээ: 14.1 0. сахь-, ахь- 1. сахи-, ахи-
14.2 0. дохь-, зохь- 1. дохи-, зохи-

сахиж, сахиад, сахин, сахисаар, сахивч, сахимагц, сахитал, сахихлаар, сахивал, сахиваас, сахимаажин, сахимааж, сахингуут, сахиут, сахингаа, сахилгүй, сахихул, сахируун

15. Заримдаг гийгүүлэгчээр төгссөн, балархай эгшигтэй үгс:

Жишээ: 15.1 0. чавхад-, нягтад- 1. чавхд-, нягтд-
15.2 0. гоход-, соронзод- 1. гохд-, соронзд-
15.3 0. нөхөц-, хөгшид- 1. нөхц-, хөгшид-
15.4 0. хүрзэд-, тэвхэд- 1. хүрзд-, тэвхд-

нөхцөж, нөхцөөд, нөхцөн, нөхөцсөөр, нөхцөвч, нөхөцмөгц, нөхөцтөл, нөхцөхлөөр, нөхөцвөл, нөхөцвөөс, нөхөцмөөжин, нөхөцмөөж, нөхцөнгүүт, нөхцүүт, нөхцөнгөө, нөхцөлгүй, нөхцөхул, нөхөцрүүн

16. “ж, ч, ш” гийгүүлэгчээр төгссөн, балархай эгшигтэй үгс:

Жишээ: 16.1 0. амташ-, давсаж- 1. амтш-, давсж-
16.2 0. хотож-, огточ- 1. хотж-, огтч-

16.3 0. мөнхөж-, бөхөж- 1. мөнхж-, бөхж-
16.4 0. энхэж-, бэхэж- 1. энхж-, бэхж-

энхжиж, энхжээд, энхжин, энхэжсээр, энхживч, энхэжмэгц, энхэжтэл, энхжихлээр, энхэжвэл, энхэжвээс, энхэжмээжин, энхэжмээж, энхжингүүт, энхжүүт, энхжингээ, энхжилгүй, энхжихүл, энхэжрүүн

Кирилл бичгээр үг хувилгахын тулд хөрвүүлэх програмын алгоритмд дээр тодорхой дурдсан нэрийн 32, үйлийн 16 бүлэг, тэд тус бүрийнх нь үгийн эшгээр зохицох 4 хувилбар, нийт 165 зүйл болно.

Хэтийн зөгнөл. Цаг төрийн амьсгалд автаж асан нэгэн үе түүхийн хуудаснаа хоцорч, эх хэлний боловсролын талаар чамгүй ярьж, хийж эхэлсэн өнөө цагт²¹ кирилл үсгийн дүрмийг шинэчлэн боловсруулах бодит шаардлагыг үндэс болгон БСШУЯ-ны шийдвэрээр төсөл баталж, уг төслийн хүрээнд хэл бичгийн эрдэмтдийн ажлын хэсэг ажиллаж, үе үе эрдэмтдийн саналыг харгалзан үзэж тусгасан, залгамал хэв шинжтэй монгол хэлний онцлогт нийцсэн дүрмийн төсөл боловсруулсан билээ.

Ингэхдээ, цагаан толгойн үсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн тогтоож, монгол хэлний үеийг *эгшиг, эгшиг + гийгүүлэгч, гийгүүлэгч + эгшиг, гийгүүлэгч + эгшиг* гэсэн 4 зүйлээр тодорхойлон үеийн бүтцийг чанд барьж, эгшиг гийгүүлэгчийн зохицлыг журамлан, үгийн үндэс, дагавар нөхцөлийн бүтцийг эвдэхгүй байхаар тусгасан тул хүчинтэй мөрдөж буй 130 гаруй дүрмээс балархай эгшгийн, дараалсан гийгүүлэгчийн, гээгдэх эгшгийн, хатуу, зөөлний тэмдгийн гэх мэтийг хасаж, зөв бичихтэй холбогдсон 10-аадхан дүрэмтэй болсон байна.²² Нийт 15 дүрмийн 11 дүгээр нь “Том үсгийг зөв бичих”, 12 дугаар нь “Үг товчлох”, 13 нь “Үг таслах”, 14 нь “Цэг тэмдэг бичих”, 15 нь “Гадаад хэлний үгийг зөв бичих” юм.

Тус зөв бичих дүрэмд түшиглэн нэг талаас, кирилл бичиг монгол хэлний зүй тогтолд тохирсон байсан бол үгийн бүлэг ямархуу байхыг сонирхон, нөгөө талаас шинээр боловсруулсан дүрэм албан ёсоор хэрэглэгдэх ахул гэдгийг давхар санан, нэгтгэвэл, хөрвүүлэх програмын хэрэглээ, алгоритмын уян хатан, дасан зохицох чадварыг бодолцон шинэ дүрэмд захируулсан үгийн бүлгийг гаргавал:

Нэр үгийн бүлэг:

1. урт эгшгээр төгссөн үгс:

Жишээ: 1.1 *авиаа, даавуу* 1.2 *болзоо, овоо*
1.3 *бөглөө, өвөлжсөө* 1.4 *сэдхилгээ, зүү*
сэдхилгээний, сэдхилгээндэ, сэдхилгээг, сэдхилгээнээс, сэдхилгээгээр,
сэдхилгээтэй

2. урт эгшгээр төгссөн үгс: Тэмдэг нэр, нэрийн хувилал авах үеийн бүлэг.

Жишээ: 2.1 *буруу, чалчиаа* 2.2 *ондоо, мохоо*

²¹ Үүнд, Монгол улсын ерөнхийлөгч Н. Багабанди 2003 оны 5-р сарын 20-ны өдөр нийт ард түмэнд гаргасан уриалгадаа “Монгол хэл бичиг сурах, сургах хялбар дөт арга замыг боловсруулж, сурах бичиг, гарын авлага олшруулах, тэрчлэн шинэ бичгийнхээ дүрмийг улам боловсронгуй болгох”-ыг онцлон тэмдэглэснийг нэгэн эш болгоё.

²² Д. Төмөртоого, *Монгол кирил бичигийн зөв бичих дүрэмийг шинэчилэн боловсруулсан тухай*, Монгол улсын төрийн хэлний зөвлөл, *Монгол хэлбичиг*, III боть, Улаанбаатар, 2006, 47-61 –р тал.

- 2.3 гөлөрөө, мөлхөө
чалчиаагийн, чалчиаад, чалчиааг, чалчиаагаас, чалчиаагаар, чалчиаатаи
- 2.4 зөрүү, эргүү
3. богино эгшгээр төгссөн үгс:
Жишээ: 3.1 аварга, баигуулга 3.2 гойо, богино
3.3 шөнө, өсөлтө 3.4 эмнэлгэ, эрдэнэ
эмнэлгэгийн, эмнэлгэд, эмнэлгэийг, эмнэлгээс, эмнэлгээр, эмнэлгэтэй
4. “и”-ээс бусад богино эгшгээр төгссөн, “н” бүхий үгс:
Жишээ: 4.1 даага, алта 4.2 йосо, олзо
4.3 мөнгө, өнгө 4.4 нүдэ, мэнгэ
йосони, йосондо, йосоийг, йосоноос, йосоор, йосотой
5. “и” эгшгээр төгссөн үгс:
Жишээ: 5.1 шавжи, сурвалжи 5.2 боломжи, хормогчи
5.3 хөрши, төхөөрөмжи 5.4 хүлэмжи, гиигүүлэгчи
боломжиин, боломжид, боломжийг, боломжиоос, боломжиоор, боломжитой
6. “и” эгшгээр төгссөн үгс:
Жишээ: 6.1 анааши, хаичи 6.2 цоожчи, дооши
6.3 бөгөжи, нөөши 6.4 гинжи, сэмжи
нөөшини, нөөшиндө, нөөшиг, нөөшинөөс, нөөшиөөр, нөөшитэй
7. хос эгшгээр төгссөн үгс:
Жишээ: 7.1 гахай, дугтуу 7.2 могои, овоохои
7.3 өлги, өехи 7.4 эрвээхи, эмэгтэй
гахайн, гахад, гахайг, гахайгаас, гахайнаас, гахайгаар, гахайтай
8. л, м буюу монгол бичгийн зөөлөн дэвсгэр гийгүүлэгчээр төгссөн үгс:
Жишээ: 8.1 санал, цуварал 8.2 ном, бодорол
8.3 хөл, өмөсхөл 8.4 дэглэм,
өмөсхөлийн, өмөсхөлд, өмөсхөлийг, өмөсхөлөөс, өмөсхөлөөр, өмөсхөлтэй
9. хэлний үзүүрийн “н” гийгүүлэгчээр төгссөн үгс:
Жишээ: 9.1 ачитан, амитан 9.2 одхон, нойон
9.3 өвчитэн, хөдөлгөөн 9.4 хүчитэн, тэмэцээн
хүчитэний, хүчитэндэ, хүчитэнийг, хүчитэнээс, хүчитэнээр, хүчитэнтэй
10. хамрын “н” гийгүүлэгчээр төгссөн үгс:
Жишээ: 10.1 сан, шаазан 10.2 орчилон, йотон
10.3 хөвөн, зөн 10.4 дүн, үзэсхэлэн
орчилонгийн, орчилондо, орчилонг, орчилонгоос, орчилонгоор, орчилонтой
11. г, д, с, р буюу монгол бичгийн хатуу дэвсгэр гийгүүлэгчээр төгссөн үгс:
Жишээ: 11.1 хизагаар, арад 11.2 йозоор, зовхис
11.3 өглөг, төлөвөр 11.4 цэцэрлэг, үлгэр
хизагаариин, хизагаарта, хизаагаарииг, хизагаараас, хизагаараар,
хизаагаартай

Үйл үгийн бүлэг

1. урт эгшгээр төгссөн үгс:

- Жишээ: 1.1 асуу, бай 1.2 боо, зохиоо
1.3 нөө, зөө 1.4 хүлээ, нээ

зохиоож, зохиоогоод, зохиоон, зохиоосоор, зохиоовчи, зохиоомогцо, зохиоотол, зохиоохлоор, зохиоовол, зохиоовоос, зохиоомоожин, зохиоомоож, зохиоонгуут, зохиоогуут, зохиоонгоо, зохиоолгүй, зохиоохул, зохиооруун

2. “и”-ээс бусад богино эгшгээр төгссөн үгс:

Жишээ: 2.1 зарла, батала 2.2 оно, боловсро

2.3 хөндө, зөөлөрө 2.4 илэрэ, эмхилэ

эмхилэж, эмхилээд, эмхилэн, эмхилэсээр, эмхилэвчи, эмхилэмэгцэ, эмхилэтэл, эмхилэхлээр, эмхилэвэл, эмхилэвээс, эмхилэмээжин, эмхилэмээж, эмхилэнгуут, эмхилүүт, эмхилэнгээ, эмхилэлгүй, эмхилэхул, эмхилэрүүн

3. “и” эгшгээр төгссөн үгс:

Жишээ: 3.1 ухаажиг, хаши 3.2 очиг, дорги

3.3 өрни, зовши 3.4 бэхэжиг, түгши

ухаажигж, ухаажигиаад, ухаажигин, ухаажигисаар, ухаажигивчи, ухаажигимагца, ухаажигитал, ухаажигихлаар, ухаажигивал, ухаажигиваас, ухаажигимаажин, ухаажигимааж, ухаажигингуут, ухаажигиуут, ухаажигингаа, ухаажигилгүй, ухаажигихул, ухаажигируун

4. “л, м” буюу монгол бичгийн зөөлөн дэвсгэр гийгүүлэгчээр төгссөн үгс:

Жишээ: 4.1 сал, далал 4.2 бол, тонил

4.3 хөтөл, цөмөл 4.4 тэмүүл,

болжиг, болоод, болон, болсоор, боловчи, болмогцо, болтол, болохлоор, болбол, болбоос, болмоожин, болмоож, болонгуут, болуут, болонгоо, бололгүй, болохул, болруун

5. “т, д, с, р” буюу монгол бичгийн хатуу дэвсгэр гийгүүлэгчээр төгссөн үгс:

Жишээ: 5.1 дас, дурад 5.2 бос, хоцор

5.3 өг, төгөс 5.4 үүс, нэгэд

төгөсчи, төгөсөөд, төгөсөн, төгөссөөр, төгөсөвчи, төгөсмөгцө, төгөстөл, төгөсөхлөөр, төгөсвөл, төгөсвөөс, төгөсмөөжин, төгөсмөөж, төгөсөнгуут, төгөсүүт, төгөсөнгоо, төгөсөлгүй, төгөсхул, төгөсрүүн

Шинэчилсэн дүрмийн төслийн дагуу бичих үед тухайн үгийг монгол бичгээр хэрхэн бичдэгтэй бараг төлөв тохирч байсан ба чингэснээр мянга гаруй жилийн турш үе үеийн хүмүүсийн санаа бодлыг тогтуун бүрэн тусгаж, эдүгээ цагийн залгамжид уламжлан дамжуулж, монгол угсаатныг хэл, бичиг соёлоор нь нэгтгэх гол цөм болж ирсэн монгол бичгийн хүчин чадал аяндаа мэдрэгдэж байсныг дурдахгүй өнгөрөхийн аргагүй юм.

III. Өнөөгийн бидний мэдлэгийн хирээр, монгол хэлний хэлзүйн бичгүүд XIII зууны үеийн дуун ухаанч Саж бандид Гунгаажалцаны зохиосон “Зүрхний толт”-оос ундаргатай. Монгол хэлшинжлэлч нар үүнээс эх авч, өдий төдий хэлзүйн бичгийг зохион туурвисаар ирсэн бөгөөд монгол бичгийн зөв бичих зүйг боловсронгуй болгоход чиглэж иржээ. Монгол бичиг олон зуун жилийг туулан, өдгөө хүртэл хэрэглэгдсээр байгаагийн гол чадамж бол залгамал хэв шинжтэй монгол хэлний онцлогт зохицсон үгзүйн зарчмыг голлон мөрддөг зөв бичих зүйтэй нягт холбоотой эргэлзээгүй юм.

Монгол бичгийн зөв бичих зүйн тулгуур үндэс нь уламжлалт хэлзүйн сурвалж бичгүүдээс үүдэлтэй “чанга хөндийн зохицол”, “дэвсгэрлэх ёсон”, “нэгэн үеийн дотор

ABSTRACT

In this paper we consider about Mongolian orthographies in the employ of translation software. The translation software between Cyrillic and Mongol script which has been developed by scientists at the National University of Mongolia and the University of Science and Technology has a number of functions: converting a text file written in Cyrillic into Mongol script and vice versa; Cyrillic spelling check; and Mongol script spelling check. The major part of the translation software is a database, which contains more than 60,000 words according to the orthography of Mongol script and Cyrillic, and a parsing algorithm.

The paper has the following parts:

1. The concepts which are used to word classification associated with orthography are:
 - Parts of Speech
 - Orthographical Classification
 - Word vowel

These concepts are the medium between word stem and its inflected form. A much more confident way of translation is via these concepts. Its combination can give perfect information about the word. The combination is represented in a code which consists of 3 parts, for example, 1.1.1. The first number indicates parts of speech; the second is for main orthographical classification; the third is for word vowel.

2. Cyrillic features and employs it to the software, and prospective preconception:
Following the Cyrillic orthography, the nouns in the database are classified into 32 main groups, and there are 16 main groups of verbs. Most groups have 4 versions because of vowels, for example, the ablative case: 'aac, ooc, oec, eec'
Cyrillic prefers phonetic principle in its orthography which is not suitable for the agglutinative Mongolian language. In 2006, an improved and more sophisticated Cyrillic orthography was developed by Mongolian philologists. This orthography prefers morphological principle, Mongolian phonetic distribution, vowel harmony, consonant harmony and it does not lead to break structures of word stem and suffixes. We figure an application of software hence made a new classification based on the improved Cyrillic orthography which is prospective preconception. According to this new version of Cyrillic orthography, nouns are classified into 11 groups and verbs into 5 groups. This is almost the same as the word classification of Mongol script. If above mentioned sophisticated Cyrillic orthography would be valid, the translation software development will be easier and hence converting process takes much less time; on the other hand one of the efficiency appears in the field of natural language processing.
3. Mongol script features and employs it to the software: According to the Mongol script orthography each of the nouns and verbs in database has 6 groups. This classification exactly corresponds with Mongol script principles: vowel harmony and consonant harmony, syllable formation and syllable closing consonant formation.